

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨГСӨН
САНАЛЫГ ХҮЛЭЭН АВСАН БАЙДАЛ**

Засгийн газраас ирүүлсэн санал	Хууль санаачлагчийн санал
<p>Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хуулиас "албаны нууц"-д холбогдох зохицуулалтыг бүхэлд нь хасаж, төрийн нууцын жагсаалтыг тухайлсан хуулиар батлахаар, төрийн нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, хугацааг сунгах зэрэг асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэхээр хуулийн төсөл боловсруулсан нь уг хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөөр байна.</p>	<p>Саналыг хүлээн авч, төслийг шинэчилсэн найруулга хэлбэрт оруулав.</p>
<p>Түүнчлэн, хуулийн төслийн хүрээнд албаны нууцад хамаарах зохицуулалтыг хассанаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалтад тус тус заасны дагуу хуулийн төслийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулах;</p>	<p>Саналыг хүлээн авч, төслийг шинэчилсэн найруулга хэлбэрт оруулав.</p>
<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эрх ашигт учруулж болзошгүй хор хохирлын хэмжээгээр нь үнэлэн гадаад бодлого, үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг албаны нууцад хамааруулдаг тул энэ хүрээнд нууцалсан мэдээллийг ил болгох, эсхүл нууцын зэрэглэл нэмэгдүүлэх талаарх зохицуулалтыг тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тодорхой тусгах;</p>	<p>Саналыг хүлээн авч, дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тусгав.</p>

<p>Төрийн нууцад хамаарах мэдээллийг зөвхөн "маш нууц", "онц чухал нууц" гэсэн зэрэглэлд хамааруулснаар 20, эсхүл 30 жил нууцлах шаардлага үүсэж байна. Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Канад Улс, Австралийн Холбооны Улс, Шинэ Зеланд Улс зэрэг хөгжингүй улс орнууд гадаад бодлоготой холбоотой нууц мэдээллийг задруулсан буюу үрэгдүүлсэн тохиолдолд учруулах хор хохирлын хэмжээгээр нь 3-4 зэрэглэлд жишгийг анхаарч, нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох</p>	<p>Саналыг хүлээн авч хуулийн төсөлд төрийн нууцын зэрэглэлд "нууц" гэсэн зэрэглэл нэмэв.</p>
<p>Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтад заасан "Хуулийн төслийн агуулга нь зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, хуулийн төслийн үзэл баримтлалд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нууцыг хуулиар тогтоон хамгаалах суурь зарчимд нийцэхгүй талаар дурдсан боловч хуулийн төсөлд эдгээр хэсэгт өөрчлөлт оруулах талаар тусгаагүй,</p>	<p>Саналд хуулийн төслийн заалтууд хоорондоо зөрчилтэй гэсэн санал ирүүлсэн боловч "Үзэл баримтлал ба төсөл" хоорондоо зөрчилтэй гэсэн санал ирүүлсэн. Төсөлд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 хэсэг нь 14 дүгээр үйлийн 14.4, 14.5 хэсэг болгон өөрчлөгдсөн ба холбогдох өөрчлөлтийг тусгав.</p>
<p>хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмэхээр тусгасан 4.3 дахь хэсэг нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байна.</p>	<p>Саналыг хүлээн авч давхардлыг засав.</p>
<p>Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтад заасан нууцад хамаарах мэдээллийн "нууц" зэрэглэлийг хүчингүй болгохоор тусгасан боловч тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтад тус тус заасан "нууц" зэрэглэлийн зохицуулалт хэвээр байгааг анхаарах;</p>	<p>Саналыг хүлээн авч хуулийн төсөлд төрийн нууцын зэрэглэлд "нууц" гэсэн зэрэглэл нэмэхээр төсөлд тусгав.</p>

**Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын дагуу батлагдах
дүрэм, журам, зааврын талаарх мэдээлэл**

1. Төрийн нууцын хамгаалалтын асуудлаар дэмжлэг үзүүлсэн хуулийн этгээд, иргэнийг урамшуулах журам /Засгийн газар, хуулийн төслийн 6.5/
2. Төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журам /Засгийн газар, хуулийн төслийн 12.2/
3. Онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам /Засгийн газар, хуулийн төслийн 14.3/
4. Төрийн нууцад авах мэдээлийн санал хүргүүлэх журам /Засгийн газар, хуулийн төслийн 14.5/
5. Төрийн нууцыг ил болгох журам /Улсын Их Хурал, хуулийн төслийн 18.6/
6. Аюулгүй байдлын шалгалт явуулах журам /Тагнуулын байгууллагын дарга, хуулийн төслийн 25.2/
7. Төрийн нууцыг хамгаалах байгууллагын дотоод журам /Тухайн байгууллагын удирдлага, хуулийн төслийн 29.5/
8. Төрийн нууцыг хамгаалах нийтлэг журам /Засгийн газар, хуулийн төслийн 30.1/
9. Тусгай шуудан хүргэх, хүлээн авах журам /Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, тагнуулын байгууллагын дарга хамтарч, хуулийн төслийн 30.4/
10. Төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих журам /Засгийн газар, хуулийн төслийн 37.5/
11. Төрийн шифр харилцааны дүрэм /Засгийн газар, хуулийн төслийн 33.3/

ХУУЛЬ САНААЧЛАГЧ



УИХ-ын гишүүн

Жергэлсайханы ЗОЛЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ
ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,

САНГАЛГА

621 2025.12.23



УИХ-ын гишүүн

Бадамдоржийн ПУНСАЛМАА

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ
ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ

САНГАЛГА

624 2025.12.23



УИХ-ын гишүүн

Хүрэлбаатарын БААСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

САНГАЛГА

632 2025.12.17



УИХ-ын гишүүн

Одонгийн ЦОГТГЭРЭЛ

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ
НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

САНГАЛГА

638 2025.12.12



УИХ-ын гишүүн

Пүрэвжавын САЙНЗОРИГ

ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ /
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

САНГАЛГА

639 2025.12.04



УИХ-ын гишүүн

Ням-Осорын УЧРАЛ

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ



УИХ-ын гишүүн

Пүрэвбаатарын МӨНХТУЛГА

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



УИХ-ын гишүүн

Аюушийн АРИУНЗАЯА

СТАТИСТИКИЙН ТУХАЙ



УИХ-ын гишүүн

Дашцэрэнгийн ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУДАЛДАН ХУРАЛДАЛЫН



УИХ-ын гишүүн

Хөххүүгийн БОЛОРМАА

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Ц.Жигжиджавын гудамж 7/1, Бага тойруу, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2026.04.01 № 02/1128

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс санаачлан боловсруулсан “Төрийн нууцын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд санал авах”-аар ирүүлсэн 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-03/2693 дугаартай албан бичгийг Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улсын дээд шүүх нь хууль тогтоох үйл ажиллагаанд оролцоходоо төрийн эрх мэдлийг хуваарилах онол, засаглалын хяналт-тэнцвэрийн зарчим болон тусгай журмыг баримталдаг. Дээрх хуулийн төслүүдтэй танилцаад дараах хууль зүйн үндэслэлээр санал өгөх боломжгүй гэж үзэв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт “...Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах...”-аар тусгайлан заасан байдаг. Уг санал авах ажиллагаа нь хууль тогтоох үйл ажиллагааны нэгдсэн арга зүй, техник бүрэн хангагдсан нөхцөлд хэрэгжих учиртай.

Хуулийн төсөл нь Засгийн газрын үндсэн чиглэлд нийцсэн эсэхийг тодорхойлж, үзэл баримтлал, хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, гарах зардлын тооцоог эрх бүхий байгууллагуудаар эцэслэн гаргуулсны дараа Улсын дээд шүүхэд ирүүлэх нь шүүн таслах ажиллагааны нэгдсэн бодлого, процессын шударга байдлыг хангах, хууль хэрэглээний практикт алдаа гарахаас урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй юм.


Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүнээс санаачилсан төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газар санал, дүгнэлт өгөх тусгайлсан дараалалтай. Гэтэл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болон Засгийн газрын албан ёсны дүгнэлт

гараагүй байхад төслийг Улсын дээд шүүхэд шууд ирүүлсэн нь санал авах урьдчилсан нөхцөл хангагдаагүй байна.

Иймд дээрх хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, журмын дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг гаргуулсны дараа Улсын дээд шүүхэд ирүүлэх нь хууль тогтоомжид нийцэх тул хуулийн төслийг танайд хүргүүлэв.

Хувийг: Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлд

ШҮҮГЧ



С.СОЁМБО-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gro@prosecutor.mn,
Цахим хуудас: www.prosecutor.mn


2026. 04. 07 № 2/1450
танай 2026. 03. 18 ны № ГИХ-03/2694

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА**

Таны 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-03/2694 дугаартай албан бичгийн дагуу Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдаж боловсруулсан хуулийн төслүүдтэй танилцаад, гаргасан саналаа хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3. хуудас.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ



15010402252



Улсын ерөнхий прокурорын газрын
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн
2. №100 дугаартай албан бичгийн хавсралт

ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ

№	Зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал			Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Нэмэх	Хасах	
0	1	2	3	4	5
Нэг. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд					
1.	<p>1 дүгээр зүйл. 1/1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “цуглуулсан, хадгалсан” гэснийг “эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж цуглуулсан, дамжуулсан, хадгалсан” гэж өөрчилсүгэй.</p>			Бүхэлд нь хасах	<p>Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5.1 дүгээр зүйлийн 5.1.1 дэх хэсэгт “төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно” гэж заасан. Төрийн нууцыг хууль бусаар олж авах гэмт хэргийн субъектийг “эрх бүхий албан тушаалтан” гэж хязгаарлах нь гэмт хэргийн улмаас хөндөгдөх эрх, ашиг сонирхол буюу үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учрах үр дагаварт нийцэхгүй. Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ямар албан тушаалтнууд хамаарах нь тодорхойгүй, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан “тодорхой, ойлгомжтой байх” шаардлагыг хангахгүй байна.</p>
Хоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд					
2.	<p>1 дүгээр зүйл. 1/1.4 дүгээр зүйлийн 1.38 дахь заалт “шүүх хуралдаан ажиглагч” гэж хуралдаан болон хаалттай нээлттэй шүүх хуралдаанд энэ шүүх хуралдаанд энэ хуульд заасан журмын дагуу</p>	<p>“...шүүх хуралдаан ажиглагч” гэж нээлттэй шүүх хуралдаанд энэ хуульд заасан журмын дагуу</p>			<p>Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд “албаны нууц” гэснийг хасаж, төрийн нууцын ангиллыг цөөлж байгаа ч хаалттай хуралдаанд хөндлөнгийн хүн (ажиглагч) байх нь нууцтай холбоотой мэдээлэл алдагдах эрсдэл үүсэхээр байна. Өөрөөр хэлбэл, хаалттай шүүх хуралдаанаар төрийн, хувь хүний нууцтай холбоотой, эсвэл хохирогчийг хамгаалах зорилгоор</p>

<p>дагуу биечлэн сууж, шүүх хуралдааны явцыг хөндлөнгөөс ажиглаж байгаа хүнийг” гэж нэмэх</p>	<p>биечлэн сууж, шүүх хуралдааны явцыг хөндлөнгөөс ажиглаж байгаа хүнийг...” гэж өөрчлөх.</p>		<p>хуралдааныг хаалттай явуулах хуулийн зохицуулалттай тул хөндлөнгийн “ажиглагч” байх нь нууцыг задруулах бодит эрсдэл үүсэж болзошгүй тул өөрчлөлт оруулах.</p>
<p>3. Төслийн 1 дүгээр зүйл. 2/3.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “нэгтгэсэн эрүүгийн хэргийн зарим нь төрийн нууцад хамаарах бол төрийн нууцад холбогдох хэргийг хаалттай явуулж бусад хэргийг нээлттэй явуулна.” гэж нэмэх</p>	<p>“... нэгтгэсэн эрүүгийн хэргийн зарим нь төрийн нууцад хамаарах бол шүүх хуралдааныг бүхэлд нь хаалттай явуулна” гэж өөрчлөх.</p>		<p>Төрийн нууцын зэрэглэлтэй баримттай хэрэг “нэгтгэгдсэн” тохиолдолд нууцыг задруулахгүй байх үүднээс хэргийг бүхэлд нь хаалттай хянан шийдвэрлэдэг. Энэ нь шүүх хуралдааны явцад нууц мэдээлэл санамсаргүй болон бусад байдлаар задрахаас сэргийлэх, нууцыг хамгаалах зарчимтай нийцэх тул өөрчлөлт оруулах.</p>
<p>4. Төслийн 1 дүгээр зүйл. 2/3.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Төрийн нууцын тухай хуульд заасан шаардлага хангасан иргэн төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд ажиглагчаар оролцохоор хүсэлт гаргасан бол шаардлага хангасан эсэхийг шүүх хуралдаан даргалагч шалгаж, хуульд заасан шаардлага хангасан бол тухайн иргэнд шүүх хуралдаанд ажиглагчаар оролцох зөвшөөрөл олгоно.” гэж нэмэх</p>		<p>Бүхэлд нь хасах</p>	<p>Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19 дүгээр зүйлд төрийн нууцтай танилцах нийтлэг нөхцөл, 20 дугаар зүйлд тусгай нөхцөлийг тусгаж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас бусад эрх бүхий этгээд зөвхөн өөрийн эрхэлж буй албан тушаал, албаны чиг үүрэгт хамаарах төрийн нууцтай танилцах эрхтэй байхаар заасан. Дагалдан боловсруулсан энэ хуулийн төсөлд “Төрийн нууцын тухай хуульд заасан шаардлага хангасан иргэн” шүүх хуралдаанд ажиглагчаар оролцож, төрийн нууцад хамаарах баримт, мэдээлэлтэй танилцахаар тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна. “Төрийн нууцын тухай хуульд заасан шаардлага хангасан иргэн” гэж хуульд нэрлэн заасан төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтныг, эсхүл нэрлэн заагаагүй боловч төрийн нууцтай танилцах шаардлагатай үндэслэлээр эрх олгогдсон иргэнийг хамааруулан ойлгох эсэх нь тодорхойгүй байх тул хуулийн төслөөс бүхэлд нь хасах.</p>

5.	<p>Төслийн 1 дүгээр зүйл. 2/3.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг “Төрийн нууцын тухай хуульд заасан зэрэглэл харгалзахгүйгээр төрийн нууцтай танилцах эрх олгогдсон этгээд төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр хуралдаанд ажиглагчаар оролцож болно.”</p>			<p>Бүхэлд нь хасах</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэж; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлана” гэж тус тус хуульчилсан. Шүүх хуралдааны ажиглагч хэргийн оролцогчийн нэгэн адил шүүх хуралдааны дэгд захирагдах бөгөөд хуралдаан даргалагч түүнийг шүүх хуралдаанд оролцуулах эсэхийг шийдвэрлэх нь шүүхийн бүрэн эрхэд хамаарах тул хуулийн төслөөс бүхэлд нь хасах.</p>
----	--	--	--	------------------------	---

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Жуулчны гудамж-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160, Утас: 9226 3656,
9226 3017, Факс: (976) 9226 3656,
Цахим шуудан: info@gia.gov.mn,
Цахим хуудас: www.gia.gov.mn

2026.03.20 № ТЭС01/200
танай 2026.03.12 -ны № ЧУХ-03/2436 -т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Гишүүний хууль санаачлах эрхийн хүрээнд Төрийн нууцын тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор мэдээлэл авах тухай албан бичигтэй танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө “Улсын нууцын тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 206 дугаар тогтоолоор БНМАУ-ын Улсын нууцын жагсаалт, зэрэглэлийг баталсан бөгөөд уг тогтоол гарсантай холбогдуулан “Улсын нууц баримт бичгийн жагсаалтыг батлах тухай” Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 330 дугаар тогтоол хүчингүй болсонд тооцсон.

Тус тогтоолоор баталсан БНМАУ-ын Улсын нууцын жагсаалтаар “Дайчилгааны бэлтгэл, нөөцийн асуудал”, “Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон иргэний хамгаалалтын асуудал”, “Эдийн засаг, шинжлэх ухаан техникийн асуудал”, “Харилцаа холбооны асуудал”, “Төрийн гадаад бодлогын асуудал”, “Бусад асуудал” гэсэн 6 хэсэгт хамаарах 47 мэдээллийг нууцалсан.

“Улсын нууцын тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 206 дугаар тогтоолыг Засгийн газрын 2003 оны 256 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.

Төрийн нууцын тухай 1995 оны хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал”, “Батлан хамгаалах”, “Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи”, “Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил”, “Цаазаар авах ялыг гүйцэтгэх журам, энэ зүйлийн 2 дахь хэсгийн “4, 5”, 3 дахь хэсгийн “2, 3”, 4 дэх хэсгийн “1”-тэй холбоотойгоор төрийн нууцад хамааруулах шаардлагатай объектууд” гэсэн хүрээгээр мэдээллийг нууцалсан.

Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай 2004 оны хуулиар “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал”, “Батлан хамгаалах”, “Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи”, “Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил”, “Бусад” гэсэн 5 хэсэгт хамаарах 60 мэдээллийг нууцалсан.

БНМАУ-ын Улсын нууцад хамааруулсан батлан хамгаалах, эдийн засаг, төрийн бодлого зэрэг дээр дурдсан асуудлын хүрээнд одоо ч нууцалсан ач холбогдол нь хэвээр байх баримт бичиг, мэдээллүүд нууцаас гараагүй хариуцсан салбар, байгууллагуудад хадгалагдаж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн болон албаны нууцын тухай 2016 оны хуулиар “Төрийн бодлого”, “Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи”, “Батлан хамгаалах”, “Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил”, “Мэдээллийн аюулгүй байдлын болон бусад” гэсэн 5 хүрээ, Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тусгагдсан 33 салбарын 575 мэдээлэл төрийн нууцад хамаарч байна.

Хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотой хүчингүй болсон мэдээллийг ил болгох ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үндэслэлээр ил болгох шийдвэрийг тухай бүр эрх бүхий байгууллагаас гаргасан.

Тухайлбал: Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасан нууцлах хугацаа дууссан үндэслэлээр 19 байгууллагын 242,793 хуудас мэдээлэл, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон үндэслэлээр Засгийн газрын 2021 оны 82 дугаар тогтоол, 2022 оны 449 дүгээр тогтоол, 2025 оны 123 дугаар тогтоолоор нийт 21,839 хуудас мэдээлэл, Тагнуулын байгууллагын хяналт шалгалтын хүрээнд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон 1,198 хуудас мэдээллийг ил болгох саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.


Түүнчлэн Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдаас Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг (Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Хууль зүй, дотоод хэргийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга) даалгасан.

Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайдын 06 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Их хуралд өргөн барихаар тогтсон.

“Улсын нууцын тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 206 дугаар тогтоол, “Улсын нууц баримт бичгийн жагсаалтыг батлах тухай” Сайд нарын Зөвлөлийн 1988 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 330 дугаар тогтоолын судалгаа мэдээлэлд ашиглагдаж байсан хувийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт №4 хуудастай.

ДАРГА



П.ОДОНБААТАР



151

**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Засгийн газрын
ТОГТООЛ**

1991 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар
хот

Улсын нууцын тухай

БНМАУ-ын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын улсын нууцын жагсаалт, зэрэглэлийг хавсралтын ёсоор баталсугай.

2. "БНМАУ-ын улсын нууцыг хадгалж, хамгаалах заавар"-ыг өнө оны 7 дугаар сард багтаан баталж мөрдүүлэхийн хамт улсын нууцын хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар /Н.БААТАР/-т даалгасугай.

3. БНМАУ-ын улсын нууцын жагсаалт, зэрэглэл, улсын нууцыг хадгалж, хамгаалах зааврыг төв аппарат, харьяа байгууллагадаа нарийн чанд мөрдөж ажиллахыг улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, үйлдвэрийн газрын удирдлагад даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын нууц баримт бичгийн жагсаалтыг батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1988 оны арван хоёрдугаар сарын 31-ний өдрийн 330 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ЫН УЛСЫН НУУЦЫН ЖАГСААЛТ, ЗЭРЭГЛЭЛ

№	Нууцлах зүйл	нууцын зэрэглэл		
		маш онц	нууц чухал	маш нууц
	I	2	3	4

НЭГ. Дайчилгааны бэлтгэл, нөөцийн асуудал

1. Улс ардын аж ахуйн дайчилгааны бэлтгэлийн нэгдсэн болон тооцоот жилийн төлөвлөгөө	+			
-лам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын дайчилгааны бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө			+	
-Сум, район, аж ахуй, үйлдвэр, албан газар, байгууллагын дайчилгааны бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө				+
2. Улсын болон дайчилгааны нөөцийн хэмжээ, байрлал, санхүүжилттэй холбогдсон мэдээ заавар			+	
3. Улс ардын аж ахуйн ажиллах хүчний баталгаажилтын нэгдсэн мэдээ, судалгаа, жагсаалт			+	
4. Төвлөрсөн нефть баазууд, тэдгээрийн ачих, буулгах байгууламжийн хүч чадалын хэмжээ, байрлалын тухай нэгдсэн мэдээ				+
5. Стратегийн ач холбогдол бүхий нисэх онгоцны буудал, зам, гүүрийн тоо, байршил, даац, ургын хэмжээ, бүтцийн тухай нэгдсэн мэдээ				+
<u>ХОЁР. Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон иргэний хамгаалалтын асуудал</u>				
6. Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбогдсон баримт материал				нууцалсан зэргээр
7. Ардын арми, УАБХБ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, зөвсөг техник, материал-техникийн хангалт, байлдах хүч чадал, бэлэн байдалтай холбогдсон				+

	1	2	3	4
нэгдсэн үзүүлэлт, зөвсөгт хүчний оперативын болон дайчилгааны бэлтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтийн мэдээ, зөвсөгт хүчнийг өөрчлөн зохион байгуулах хэтийн төлөвлөгөө, бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, цэрэг армийг шилжүүлэн байрлуулах, татан буулгахтай холбогдсон тооцоо, мэдээ			+	
8. Ардын арми, УАБХБ-уудын дэлгэрэнгүй төсөв, түүний гүйцэтгэл			+	
9. БНМАУ-ын Засгийн газар, байгууллагаас гадаад орны засгийн газар, байгууллагатай улсыг батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах асуудлаар байгуулсан нууц гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээ				нууцалсан зэргээр
10. Улсын хилийн хамгаалалт, оперативын төлөвлөгөө, улсын агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах системийн бүтэц, зохион байгуулалт, зөвсөглэмж, байдлааны боломж, эдгээрт холбогдох нэгдсэн мэдээ			+	
11. УАБХБ, цагдаа, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын гүйцэтгэх ажлын арга хэлбэр, үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох баримт бичиг, архивын материал			+	
12. БНМАУ-ын шифр, түүний түлхүүр, тэдгээрт холбогдох баримт бичиг, материал, арга техник хэрэгсэл		+		
13. Цэргийн анги нэгтгэлийн тоо, бүтэц, зохион байгуулалт, жинхэнэ нэр, байршлын схемийн нэгдсэн мэдээ			+	
14. Цэргийн албан хаах үүрэгтэн болон цэрэгт татагдах, цэргээс халагдах хүний тооны тухай нэгдсэн мэдээ				+
15. Бэлтгэл цэргийн албан хаагчдын тоо, мэргэжлийн ялгааны нэгдсэн мэдээ			+	
-улсын хэмжээнд			+	
-аймаг, хотын хэмжээнд				+
16. Цэргийн удирдлага, түүний автомажчилсан системийн бүтэц, зохион байгуулалт хангалт, мэдээллийн сан, зураг төсөлд холбогдох баримт бичиг мэдээ		+		

I	1	2	1	3	1	4
17. Нууц зэвсэг, цэргийн техник, хэрэгс- лийн нэр, төрөл, техникийн егөгдөхүүн, хэрэглэх түлшний нэр төрөл, зарцуу- лалтын тухай нэгдсэн мэдээ		+				
18. Байлдааны техник, зэвсэг, галт хэрэгс- лийн хангалтын захиалгын нэгдсэн мэдээ				+		
19. Байлдааны зэвсэг техникийн ашиглалт, моторресурсын хугацаа, норм, ашиглалтын зардлын нэгдсэн мэдээ						+
20. Цэргийн анги, нэгтгэлийн хүнс, аж ахуй, санхүүгийн хангалт, захиалгын нэгдсэн мэдээ тайлан						+
21. Зэвсэгт хүчний оперативийн удирдлагын командын байр, холбооны зангилаа, радио- локац, пелегатор, радио техникийн хэ- рэгслийн зохион байгуулалт, байршил, үелзлэлийн хуваарилалтын нэгдсэн мэдээ				+		
22. Цэрэг, иргэний хамгаалалтын анги, хот- хон, тусгай объектын зураг төсөл, схем байгуулах нэгдсэн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ						+
23. БНМАУ-ыг батлан хамгаалах зориулалт- тай болон хүн ам төвлөрсөн газруудад ашиглагдаж байгаа уст цэг, нөөцөд зо- риулж гаргасан уст цэгийн солбилцол, хүч чадлын үзүүлэлт /гүн, статик, динамик төвшин, диаметр, ундарга/-ийн нэгдсэн мэдээ, байршлын зураг, схем						+
24. Улсын иргэний хамгаалалтын операти- вын төлөвлөгөө				+		
-Иргэний хамгаалалтын улсын албад, аймаг, хотын онцгой үеийн арга хэм- жээний төлөвлөгөө						+
25. Улсын иргэний хамгаалалтын удирд- лага, холбоо зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, зарч- мыг илэрхийлсэн баримт бичиг						+
26. Улсын иргэний хамгаалалтын удирдла- гын болон зориулалтын хоргодох байр- ны зураг төсөл, байршил, хүчин чадлын тухай нэгдсэн мэдээ						+
ГУРАВ. <u>Эдийн засаг, шинжлэх ухаан тех- никийн асуудал</u>						
27. Улсын алт, мөнгө болон валют, мөнгөн тэмдэгтийн нөөцтэй холбогдсон баримт бичиг, мэдээ						+

	I	I	2	I	3	I	4
30. Улсын мөнгөн тэмдэгтийг шинээр хэвлэх, хуучныг устгах, үнэт зүйлийг тээвэрлэх ажиллагаа, түүнд холбогдсон баримт бичиг							+
30. Алт, мөнгө, ураны хүдрийн район, ордын батлагдсан нөөцтэй холбогдсон баримт бичиг							+
30. Гадаад худалдааны үнийн хэлэлцээрийн үндэслэл, санал /төслийн шатанд/							+
31. Ижиглэн худалдах үнийн өөрчлөлттэй холбогдсон санал баримт бичгүүд /төслийн шатанд/							+
32. Гадаад худалдааны төлбөрийн баланс /орон тус бүрээр/							+
33. Хувь хүний банкин дахь мөнгөн хадгаламж							+
34. Шинжлэх ухааны нөөлт, УААА, цэргийн салбарт онцгой ач холбогдолтой шинэ бүтээл, эрдэм шинжилгээний материал, техник, технологийн болон шинжлэх ухаан техникийн урьдчилсан төлөвлөгөө, төслийн баримт бичиг, эрдэм шинжилгээний ажлын дэлгэрэнгүй тайлан, гүйцэтгэл							+
35. БНМАУ-ын шинэ бүтээл, ШУТ-ийн ололтыг дотоод, гадаадад дамжуулах лицензийн гэрээтэй холбоотой ажлын баримт бичиг							+
36. Үнэмлэхүй солбилцолтой I:5000, I:10000, I:25000, I:50000, I:100000, I:200000 масштабтай байр зүйн зураг <u>ДӨРӨВ. Харилцаа холбооны асуудал</u>							+
37. БНМАУ-ын хот хоорондын холбос, мэдээлэл дамжуулах системийн дэлгэрэнгүй схем						+	
38. Засгийн газрын өндөр үелэлэлийн холбооны системийн схем						+	
39. Улс хоорондын болон хотын холбооны кабель шугамын дэлгэрэнгүй схем <u>ТАВ. Төрийн гадаад бодлогын асуудал</u>							+
40. Төр, засгийн гадаад харилцааны бодлого, байр суурь, энэ талаар боловсруулж буй баримт бичиг							+

5.

I	!	2	!	3	!	4
41. БНМАУ-аас гадаад орнуудтай байгуулсан нууц гэрээ, хэлэлцээр, протокол, санамж, бичиг, тэдгээрийн гүйцэтгэл						нууцалсан зэргээр
42. Тус улсаас гадаад улсад суугаа алчин сайд, олон улсын байгууллагын байнгын төлөөлөгч нарт болон олон улсын хурал чуулганд оролцох төлөөлөгчдөд өгсөн ажлын удирдамж, чиглэл, гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт ярианы тэмдэглэл						нууцалсан зэргээр
43. БНМАУ-ын дипломат шуудан						+
<u>ЗУРГАА. Бусад асуудал</u>						
44. Төр, засгийн хаалттай хуралдаанаар хэлэлцсэн асуудал, түүнд холбогдох баримт материал						нууцалсан зэргээр
45. Төрийн ордны цогцолбор, БНМАУ-ын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, ерөнхий сайдын өргөө, монгол банк, Батлан хамгаалах яам, Улсын ажуулгүй байдлыг хангах байгууллагын байр, Засгийн газрын зочид буудлын зураг төсөл, холбооны шугамын монтаж, схем, харуул хамгаалалтын зохион байгуулалт						+
46. Цаазаар авах ял гүйцэтгэх журам, ажиллагаа, түүнийг гүйцэтгэсэн тухай баримт бичиг, материал						+
47. Төрийн нууц хамгаалах систем, хамгаалалтын техник хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, түүнд холбогдох баримт бичиг						+

нууцын зэргийг /+/ гэж тэмдэглэв.



Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1988 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 330

Улаанбаатар
хот

Улсын нууц баримт бичгийн жагсаалтыг батлах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Улсын нууц баримт бичгийн жагсаалт"-ыг хавсралтын
шоор шинэчлэн баталсугай.

2. Улсын нууц бичиг хэргийг хөтлөх зааврыг 1989 оны I дү-
гээр сард багтаан шинэчлэн баталж, уг зааврын мөрдөлт, улсын
нууцны хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Нийгмийг
шоулаас хамгаалах яам /н.ЖАМСРАНЖАВ/-д даалгасугай.

3. "Улсын нууц баримт бичгийн жагсаалт", "Улсын нууц бичиг
хэргийг хөтлөх заавар"-ыг төв аппарат, харьяа байгууллагад хэ-
рэгжүүлэхийг яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын
АДХ-н гүйцэтгэх захиргаалад даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын нууц бичиг
хэргийн заавар, нууц бичиг баримтын жагсаалт батлах тухай"
Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
622 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.




БНМАУ-ын Сайд нарын
Зөвлөлийн дарга

Д.СОДНОМ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

З.СААРАЛ



НУУЦ

Сайд нарын Зөвлөлийн 1988 оны
330 дугаар тогтоолын хавсралт

БНМАУ-ЫН УЛСЫН НУУЦ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Нууцлах зүйл	Нууцын зэрэг		
	Мал нууц онц чухал	Мал нууц	Нууц
I	2	3	4
<u>Нэг. Дайчилгааны бэлтгэл, нөөц баталгаажилтын асуудал</u>			
1. Улс ардын аж ахуйн дайчилгааны бэлтгэлийн нэгдсэн болон тооцоот жилийн төлөвлөгөө	+	-	-
-Ням, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын дайчилгааны бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө	-	+	-
-Сум, район, аж ахуй, үйлдвэр, ахбан газар, байгууллагын дайчилгааны бэлтгэлийн болон тооцоот жилийн төлөвлөгөө	-	-	+
2. Улсын болон дайчилгааны нөөцийн хэмжээ, байрлал, санхүүжилттэй холбогдсон мэдээ, заавар	-	+	-
3. Улс ардын аж ахуйн ажиллах хүчний баталгаажилтын нэгдсэн мэдээ, судалгаа, жагсаалт	-	+	-
4. Төвлөрсөн нефть баазууд, тэдгээрийн ачлх, буулгах байгууламжийн хүч чадалын хэмжээ, байршлын тухай нэгдсэн мэдээ	-	-	+
5. Стратегийн ач холбогдол бүхий нисэх онгоцны буудал, зам, гүүрийн тоо, байршил, даац, уртын хэмжээ, бүтцийн тухай нэгдсэн мэдээ	-	-	+
<u>Хоёр. Батлан хамгаалах, Улсын аюулгүй байдлыг хангах болон иргэний хамгаалалтын асуудал</u>			
6. Зэвсэгт хүчин, нийгмийг аюулаас хамгаалах байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, зэвсэг, техник, материал-техниклийн хангалт, байлдах хүч чадал, бэлэн байдалтай холбогдсон нэгдсэн үзүүлэлт, зэвсэгт хүчний опе-			

	I	2	3	4	
ративын болон дайчилгааны бэлтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийн биелэлтийн мэдээ, зэвсэгт хүчнийг өөрчлөн зохион байгуулах хэтийн төлөвлөгөө, байлдааны байнгын, өндөржүүлсэн, "дайнн аюул", бүрэн бэлэн байдлын болон цэрэг армийг шилжүүлэн байрлуулах, татан буулгахтай холбогдсон нэгдсэн мэдээ					16. Нууц : төрөл тулшн хай н
7. Зэвсэгт хүчин, нийгмийг аюулаас хамгаалах байгууллагуудын дэлгэрэнгүй төсөв, түүний гүйцэтгэл					17. Байлд ханга мэдээ
8. БНМАУ-ын Засгийн газар, байгууллагаас гадаад орны Засгийн газар, байгууллагатай улсыг батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах асуудлаар байгуулсан нууц гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээ					18. Байлд ресур лын н
9. Улсын хилийн хамгаалалт, оперативын төлөвлөгөө, эдгээрт холбогдох нэгдсэн мэдээ					19. Цэрги тосло ханга
10. Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын гүйцэтгэх ажлын арга хэлбэр, үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг					20. Цэрги сэтгэ
11. БНМАУ-ын шифр, түүний түлжүүр					21. Зэвсэ кац, :
- яам, улсын хороо, тусгай газрын шифр, түүний түлжүүр					зохио. хуваа
12. Цэргийн анги, нэгтгэлийн тоо, удирдлагын зохион байгуулалт, жинхэнэ нэр хаяг, байршлын схемийн нэгдсэн мэдээ					22. Коман хүрэх техни
13. Цэргийн албан хаах үүрэгтэн болон цэрэгт татагдах, цэргээс халагдах хүний тооны тухай нэгдсэн мэдээ					цэрги байгу, зураг
14. Бэлтгэл цэргийн албан хаагчдын тоо, мэргэжлийн ялгааны нэгдсэн мэдээ					23. Цэрги кийн
- улсын хэмжээнд					турши
- аймаг, хотын хэмжээнд					24. Цэрги лэдэг хион
15. Цэргийн удирдлагын зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн хангалт, нэр төрөл, тактик, техникийн өгөгдөхүүний нэгдсэн мэдээ					тоо х 25. БНМАУ тол а зоригу. чадлы диаме

1 4

	I	!	2	!	3	!	4
	10. Нууц зэвсэг, техникийн хэрэгслийн нэр төрөл, техникийн өгөгдөхүүн, хэрэглэх түлшний нэр төрөл, зарцуулалтын тухай нэгдсэн мэдээ		+		-		-
	17. Байлдааны техник, зэвсэг, галт хэрэгслийн хангалтыг тодорхойлсон захиалтын нэгдсэн мэдээ	-			+		-
	18. Байлдааны зэвсэг техникийн ашиглалт, моторсурсийн хугацаа, норм, ашиглалтын зардлын нэгдсэн мэдээ	-			+		-
	19. Цэргийн анги, нэгтгэлийн хүнс, шатахуун, тослогооны материал, аж ахуй, санхүүгийн хангалт, захиалтын нэгдсэн мэдээ, тайлан	-			+		-
	20. Цэргийн улс төр, ёс суртахууны болон санаа сэтгэлийн байдлын тухай нэгдсэн судалгаа	-			-		+
н зэргээр	21. Зэвсэгт хүчний холбооны зангилгаа, радиолокац, пеленгатор, радио техник хэрэгслийн зохион байгуулалт, байршил, үелзлэлийн хуваарилалтын нэгдсэн мэдээ	-			+		-
	22. Командын байр, харвах суурь, полигон, түүнд хүрэх зам, бие бүрэлдэхүүн, байлдааны зэвсэг, техникийн хэрэгслийн агуулах, далдлах байр, цэргийн анги, хотхон, тусгай объектыг барьж байгуулах нэгдсэн төлөвлөгөө, тэдгээрийн зураг схем, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээ	-			+		-
н зэргээр	23. Цэргийн салбарт гарсан шинжлэх ухаан, техникийн нээлт, шинэ бүтээл, оновчтой санал, туршилтын тухай нэгдсэн мэдээ						нууцалсан зэргээр
	24. Цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн хүч чадал, байрлал, зохион байгуулалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээний нэгдсэн мэдээ	-			-		+
	25. БНМАУ-ыг батлан хамгаалах болон тусгай объектод ашиглагдаж байгаа уст цэг, мөн нөөцөд зориулж гаргасан уст цэргийн солбиолцол, хүч чадлын үзүүлэлт /гүн, статик, динамик төвшин, диаметр, ундарга/-ийн нэгдсэн мэдээ	-			-		+

I	1	2	1	3	1	4
26. Иргэний хамгаалалтын оперативын болон нүүлгэн шилжүүлэх, тарааж байрлуулах, тогтвортой ажиллагааг хангахтай холбогдуулан улсын хэмжээнд болон яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын хэмжээнд боловсруулсан нэгдсэн төлөвлөгөө	-	+	-			
27. Иргэний хамгаалалтын холбоо, зарлан мэдээллийн зохион байгуулалтын нэгдсэн схем, судалгаа -яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын хэмжээнд гаргасан схем, судалгаа	-	+	-			
28. Иргэний хамгаалалтын штаб, мэргэжлийн ангийн орон тоо, бүтэц, зохион байгуулалтын нэгдсэн мэдээ, цэргийн анги, нэгтгэл, иргэний хамгаалалтын алба, штаб, бусад байгууллагын харилцан ажиллах нэгдсэн төлөвлөгөө	-	+	-			
29. Байлдааны үед иргэний хамгаалалтад ашиглах тээврийн болон зам, барилгын техник хэрэгслийн тухай нэгдсэн мэдээ	-	-	+			
30. Иргэний хамгаалалтын ажиглалт, лабораторийн хяналт хийх нэгдсэн түшиц газар, салбар, постын тухай нэгдсэн мэдээ	-	-	+			
31. Иргэний хамгаалалтын бүх шатны удирдлагын байр болон хамгаалах байгууламжийн зураг төсөл, байршил, хүч чадлын тухай нэгдсэн мэдээ	-	-	+			
<u>Гурав. Элийн засаг, шинжлэх ухаан техникийн асуудал</u>						
32. Улсын алт, мөнгө болон валют, мөнгөн тэмдэгтийн нөөцтэй холбогдсон баримт бичиг	-	+	-			
33. Мөнгөн тэмдэгтийг шинээр хэвлэх, хуучныг устгах, үнэт зүйлийг тээвэрлэхтэй холбогдсон баримт бичиг	-	-	+			
34. Гадаад худалдааны үнийн хэлэлцээрийн үндэслэл, санал /төслийн шатанд/	-	-	+			
35. Ижиглэн худалдах үнийн өөрчлөлттэй холбогдсон төсөл /төслийн шатанд/	-	-	+			
						36. ЭЗХТЭ-и хороо, нууцад
						37. Гадаад ланс, г тоо мэд
						38. Гадаад талын г бичиг, тохирол
						39. Хөдөлмө данс
						40. Улс ард онц ач тээл, с баримт
						41. БНМАУ-ы байгаа /төслий
						42. Стратег дийн с
						43. Энэ жил агуулса тайлан.
						44. БНМАУ-и гуулал: лах да
						45. Засгийн систем рафын :
						46. Радио, авах с
						47. Улс хо дэлгэр

	I	I 2	I 3	I 4
36. ЭЗХТЗ-ийн чуулган, гүйцэтгэх хороо, бусад хороо, байнгын комиссуудын хуралдааны нууцад хамаарах шийдвэр, баримт бичиг				нууцалсан зэргээр
37. Гадаад худалдааны төлбөрийн нэгдсэн баланс, гадаад зээл, хүүгийн тухай нэгдсэн тоо мэдээ	-	-	-	+
38. Гадаад орнуудтай байгуулсан хоёр болон олон талын гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичиг, тэдгээрийн гүйцэтгэл /нууцлахаар тохиромжсон бол/	-			нууцалсан зэргээр
39. Хөдөлмөрчдийн хувийн хадгаламжийн нэрийн данс	+	-	-	+
40. Улс ардын аж ахуйд шинжлэх ухаан техникийн онц ач холбогдол бүхий нууцалсан нээлт, бүтээл, оновчтой санал, технологи, техникийн баримт бичиг	-			нууцалсан зэргээр
41. БНМАУ-ын гадаад улсад худалдахаар төлөвлөж байгаа патент, лицензийн баримт бичиг /төслийн шатанд/	+	-	-	+
42. Стратегийн ач холбогдолтой радио идэвхт бодисын судлагдсан, батлагдсан нөөцийн хэмжээ	+	-	-	+
43. Энэ жагсаалтад орсон нууц баримт бичгийг агуулсан төлөвлөгөө, төсвийн дэлгэрэнгүй тайлан, гүйцэтгэл	+			нууцалсан зэргээр
<u>Дөрөв. Харилцаа холбооны асуудал</u>				
44. БНМАУ-ын хот хоорондын холбооны зохион байгуулалт, мэдээлэх дамжуулах систем байгуулах дэлгэрэнгүй болон бүрдүүвч схем	-	-	+	-
45. Засгийн газрын өндөр үелзлэлийн холбооны систем болон улс хоорондын телефон, телеграфын холбооны зохион байгуулалтын схем	-	+	-	-
46. Радио, радио релейний нэвтрүүлэх, хүлээн авах станцуудын харилцаанд ашиглах үелзлэл	-	+	-	+
47. Улс хоорондын болон хотын кабель шугамын дэлгэрэнгүй болон бүрдүүвч схем	-	-	-	+

I	!	2	!	3	!	4
48. Холбооны зангишгаа, бүх төрлийн холбооны шугамын /агаарын болон кабелт шугам, радио релейний шугам/ завсарын станцууд, радио-телевизийн станцын байрлалын дэлгэрэнгүй тодорхойлолт	-		+		-	
Тав. Улс төрийн гадаад бодлого, үзэл суртлын үйл ажиллагаа						
49. Гадаад харилцааны асуудлаар засгийн газрын бодлого, байр суурийг төлөвлөн боловсруулж буй баримт бичиг /төслийн шатанд/	-		-		+	
50. Ах дүү орнуудтай байр сууриа зохицуулж уялдуулсан уулзалт, зөвлөлтөөнд хэлэлцсэн асуудал /нууцлахаар тохиролцсон бол/						нууцалсан зэргээр
51. Тус улсаас гадаад улсад суугаа элчин сайд, олон улсын байгууллагын байнгын төлөөлөгч нарт болон олон улсын хурал чуулганд оролцох төлөөлөгчдөд өгсөн ажлын удирдамж, чиглэл, гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл /нууцлахаар тохиролцсон бол/						нууцалсан зэргээр
52. Хөрөнгөтөн болон хөгжиж байгаа орнуудтай харилцах улс төр, эдийн засгийн бодлоготой холбогдсон асуудал /төслийн шатанд/	-		-		+	
53. Үзэл суртлын сөрөг нэвтрүүлэгт оруулахаар бэлтгэж буй баримт бичиг /төслийн шатанд/	-		-		+	
Зургаа. Бусад асуудал						
54. Засгийн газрын ордон, улсын банк, Батлан хамгаалах яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Улс төрийн Товчооны гишгүүдийн байр, Төв Хороо, Засгийн газрын зочид буудал, амралтын газар, тус улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газар, олон улсын байгууллага, байнгын төлөөлөгчдийн байр, конторын зураг төсөл, ус, цахилгаан, холбооны шугамын монтаж, схем, харуул хамгаалалтын албаны зохион байгуулалт	-		-		+	

66. Үнэмлэхү
I: 25000,
масштабт

66. Тус улсы
зураглал

67. Геодези,
гравимет

68. Хаалттай
зурваст

69. Цэвэр ус
схем, тэ

70. Шилжүүлсэн
холобогдо

71. Энэ жагс
хий байг

72. Энэ жагс
хий байг

73. Энэ жагс
хий байг

74. Энэ жагс
хий байг

75. Энэ жагс
хий байг

76. Энэ жагс
хий байг

77. Энэ жагс
хий байг

78. Энэ жагс
хий байг

79. Энэ жагс
хий байг

80. Энэ жагс
хий байг

81. Энэ жагс
хий байг

82. Энэ жагс
хий байг

83. Энэ жагс
хий байг

84. Энэ жагс
хий байг

85. Энэ жагс
хий байг

ТАЙЛБ

